

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 12 сар 04 өдөр

Дугаар 412

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн
хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам" шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хавсралтын дагуу шинэчлэн тогтоосугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан "Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Хорооны 2008 оны 169 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн байгууллагууд нь эрхлэх үйл ажиллагааны төрөл чиглэлээс хамааруулан 2017 оны 01 дүгээр сарын 01-ний дотор хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээгээ энэ тогтоолын хавсралтад заасан хэмжээнд хүргэхийг тэдгээрийн хувь нийлүүлэгчид, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийн Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА

З.НАРАНТУЯА

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭ

/сая төгрөгөөр/							
№	Тусгай зөвшөөрлийн ангилал	Эрхлэх үйл ажиллагаа	Аймгийн төвийн сумаас бусад сум	Аймгийн төвийн сум	Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум	Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүрэг	Улаанбаатар хотын бусад дүүрэг
1.	Гадаад валютын арилжаа эрхлэх	гадаад валютын арилжаа /дангаар эрхлэх/	50.0				100.0
		гадаад валютын арилжаа болон цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	100.0				200.0
2.	Зээлийн үйл ажиллагаа эрхлэх		20.0	50.0	200.0	200.0	800.0
3.	Итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх		50.0	100.0	500.0	500.0	2,000.0